



САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр.
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,
<http://www.mnh.gov.mn>

2018. 06. 25 № 01/1753
танай _____-ны № _____-г


Үндсэн чиглэлийн биелэлт
хүргүүлэх тухай

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, үйл ажиллагааны эхний хагас жилийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хүргүүлж байна.

Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 14 арга хэмжээг хяналтанд авч, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэл 2018 оны эхний хагас жилийн байдлаар 50,0 хувьтай, төлөвлөгдсөн арга хэмжээнээс, 7 арга хэмжээ 70 хувь, 4 арга хэмжээ 40 хувийн тус тус хэрэгжилттэй байна.

Хавсралт 15 хуудастай.


СУМИЯБААЗАР

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2018 оны эхний хагас жилийн байдлаар/

2018 оны 06 дугаар сарын 21-ний өдөр

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл дэх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээг шалгуур үзүүлэлт тус бүрээр нь хяналтанд авч (Хавсралт 1), гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, шийдвэр гаргах түвшний удирдлагуудыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 18 зорилт, арга хэмжээ тусгагдсан ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь “Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого”-ын 4 дэх “Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ” зорилтын хүрээнд 5 арга хэмжээ, 14 шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлнэ.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг тус тус удирдлага болгов.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)-ны Геологийн бодлогын газар, Уул уурхайн бодлогын газар, Хүнд үйлдвэрийн бодлогын газар болон Ашигт малтмал, газрын тосны газраас тайлагнасан биелэлтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж (хавсралт 2), шалгуур үзүүлэлт тус бүрээр зарцуулах хөрөнгийн эх үүсвэр, тэдгээрийн төлөвлөлт, гүйцэтгэлийг нэгтгэсэн.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1.5 дах заалтын дагуу нотлох баримтыг үндэслэж, мөн үндсэн чиглэлийн зорилтыг хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах үр дүнг үнэлгээ хийх үед хүрсэн бодит үр дүнгийн түвшин, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлтэй харьцуулан, биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг өгсөн.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан “Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ” 4 дэх зорилтын 5 арга хэмжээ, 14 шалгуур үзүүлэлтийн 2018 оны эхний хагас жилийн биелэлт 50.0 хувьтай, үүнээс 7 шалгуур үзүүлэлт нь 70 хувь, 4 шалгуур үзүүлэлт нь 40 хувийн хэрэгжилттэй, 2 шалгуур үзүүлэлт нь 0 хувьтай, “үнэлгээ өгөх боломжгүй” шалгуур үзүүлэлт 1 байна. (Хүснэгт 1)

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
НЭГТГЭЛ**

(2018 оны эхний хагас жилийн байдлаар)

Хүснэгт 1

Дугаар	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Арга хэмжээний биелэлт, хувиар					Биелэлт, хувиар
			100	70	40	0	/-/	
1	2	3	4	5	6	7	8	9
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО								
Зорилт 4. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.								
4.1	Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх	5	0	4	0	1	0	56,00
4.2	"Алт-2" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол орны алтны хэтийн төлөвийг тогтоох	1	0	0	1	0	0	40,00
4.3	Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	3	0	2	0	0	1	70,00
4.4	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	4	0	1	3	0	0	47,50
4.5	Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих	1	0	0	0	1	0	0
		14	0	7	4	2	1	50,00

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 5 арга хэмжээний 14 шалгуур үзүүлэлтүүд нь дараахь хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжиж байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгөөр 2 арга хэмжээний 6 шалгуур үзүүлэлт,
2. Хувийн хөрөнгөөр 2 арга хэмжээний 5, шалгуур үзүүлэлт,
3. Гадаад эх үүсвэрээр 1 арга хэмжээний 1 шалгуур үзүүлэлт,
4. ТХХТ-ийн эх үүсвэрээр 1 арга хэмжээний 1 шалгуур үзүүлэлт,
5. Хөрөнгийн эх үүсвэргүй 1 арга хэмжээний 1 шалгуур үзүүлэлт.

Үндсэн чиглэлийн зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай; илүү сайн тодорхойлох шаардлагатай, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй; шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан дараахь 8 шалгуур үзүүлэлт байна. Үүнд:

1. "Эрчимжүүлэх шаардлагатай" 40 хувийн биелэлттэй 4 шалгуур үзүүлэлт
 - 1.1. "Алт-2" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол орны алтны хэтийн төлөвийг тогтоох
 - 1.2. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар
 - 1.3. "Уул уурхай, металлургийн цогцолбор" төслийн 2 дугаар шатны бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар
 - 1.4. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар

2. “Үр дүнгүй” 0 хувьтай 2 шалгуур үзүүлэлт
 - 2.1. Геохимийн зураг зохиох ажилд хамрагдах газар нутгийн хэмжээ, хувиар /1:1000000-ын масштаб/
 - 2.2. Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих
3. “Үнэлэх боломжгүй” 1 шалгуур үзүүлэлт
 - 3.1. Гацууртын төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжсэн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4 дэх зорилтын 5 арга хэмжээний 14 шалгуур үзүүлэлт нь 50.00 хувьтай үнэлэгдэв.
2. Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх 4.1 дугаартай арга хэмжээний 5 шалгуур үзүүлэлт тус бүрт зарцуулах улсын төсвийн хөрөнгө нь Сангийн яаманд хүргүүлсэн төсөл, Улсын Их Хурлын 2017 оны 42 дугаар тогтоолоор баталсан төсвийн дүнтэй тохирохгүй, зарим нэр төрлийн ажлыг хэрэгжүүлээгүй байна.
3. Геологийн судалгааны ажлуудаар геологийн тогтцын ямар асуудлуудыг шийдсэн, өмнөх шатны судалгаагаар тогтоогдсон үнэт металл, холимог металл, металл бус ашигт малтмал, барилгын материалын, шатах ашигт малтмал, ундрах усны хэдэн илрэл, эрдэсжсэн цэг, геохимийн гажил, геофизикийн гажлыг баталгаажуулсан, шинээр тогтоосон, баталгаажуулаагүй, ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээг өснөөр Монгол орны эрдэс баялгийн хэмжээг нэмэгдүүлсэн, хэдэн аймгийн нутаг дэвсгэр дэх түүхэн дурсгалт газар, олдворыг нэгтгэн, мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байдал зэргийг биелэлтэнд огт дурдахгүй байгаа нь геологийн судалгааны ажлын үр дүн, үр өгөөжийг олон нийтэд таниулах талаар санаачлагатай ажиллахгүй байна.
4. Ашигт малтмал олборлох, баяжуулах, газрын тос боловсруулах үйлдвэр нь тасралтгүй, удаан хугацаанд ажиллахад шаардлагатай түүхий эдийн нөөцийг бэлтгэх геологийн судалгааны ажлыг эрчимжүүлэх, хүнд үйлдвэрээ дагасан бүтээн байгуулалт зэрэг асуудлуудад бодлогын түвшинд хангалтгүй ажиллаж байна.
5. Яам, агентлагийн мэргэжлийн газар, хэлтсүүд нь хариуцсан асуудлаар тооцоо судалгаа, нэгтгэл, дүн шинжилгээ хийхгүй, албан хэрэгцээнд шаардлагатай материалууд байхгүй байна.
6. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын бодлого, төлөвлөлтийг нэгтгэн зангидах нэгдсэн бодлого, төлөвлөлтийн нэгжгүй, яамны бодлого, төлөвлөлтийн газрууд, бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар нь чиг үүргийн давхцал, хийдэлтэйн уршгаар зарим ажлууд нь эзэнгүйдэж, хэрэгжилт нь хангагдахгүй байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ.

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу зорилтот түвшин, баримт нотолгоо, зарцуулсан хөрөнгөний гүйцэтгэлд үндэслэн хүрсэн үр дүн, ажлын чанар, үр өгөөжид мэргэжлийн өндөр түвшинд анхаарч, тайлан, мэдээг хугацаанд нь үнэн бодит тайлагнаж хэвших шаардлагатай байна.
2. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хэтийн болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр төсвийн хүрээний мэдэгдэл, үндсэн чиглэлийг боловсруулах шаардлагатай байна.
3. Удирдлагын түвшинд газар, хэлтсүүдийн чиг үүргийн давхцал, хийдлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хавсралт:

1. "Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-д тусгагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнд хийсэн дүн шинжилгээ
2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг тайлагнах хүснэгт (Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам)

Нийт ... хуудас

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Хянасан: ХШУДАГ-ын дарга



Ц.Одхүү

ХШҮ, нэгтгэл хийж, танилцуулга боловсруулсан:

ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

Н.Баатар /2018.06.25/

ХШҮ хийсэн:

ХШУДАГ-ын мэргэжилтэн



Д.Батнайрамдал



Х.Цэнд-Аюуш



С.Цэцэг-Өлзий

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
(УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ)

18 оны эхний хагас жилийн байдлаар

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр /тэрбум төгрөг/	Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэг жил тийн хувь
1	2	3	4	5	6		
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО							
Зорилт 4. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.							
4.1.	МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.59-2.61, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /цаашид ТЭБСББ/-ын 3.2.2 дахь заалт	Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар /1:50000 масштаб/	42	11.8 Улсын төсөв	Үр дүнгийн тайлантай 11 төслөөс Бурхант толгой-50, Цогт-50, Дэвсгийн нуруу-50, Улаан толгой-50, Хулгарын элс-50, Хөхөлзөгийн говь-50, Бударын чулуу-50, Шивээт уул-50, нийт 8 төслийн үр дүнг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэж, Бударын чулуу-50, Шивээт уул-50 төслүүдийн үр дүнг УУХҮС-ын А/84, А/15 дугаар тушаалуудаар хүлээн авсан. Дээрх төслүүдийг хэрэгжүүлж дууссанаар нутаг дэвсгэрийн 38.7%-ийг бүрэн хамруулсан. 2018 онд 18 төслийг нутаг дэвсгэрийн 4%-д хэрэгжүүлэн ажиллахаар төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар батлан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Төслүүдийн 2018 оны ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийг хэлэлцсэн ЭБМЗ-ийн дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 6-р сарын 21-ний өдрийн А/158 дугаар тушаалаар төсөвт тодотгол хийж баталсан. Үр дүнгийн тайлантай болон үргэлжлэн хэрэгжиж байгаа төслүүдийг хэрэгжүүлснээр нийт нутаг дэвсгэрийн 42.7%-ийг судалгаанд хамруулна. 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд 2018 онд 4,693,697,411.0 төгрөг батлуулж, 5 дугаар сарын байдлаар 1,061,156,045.0 төгрөгийн гүйцэтгэлтэй байна.	70
			Улсын геологийн иж бүрдэл зургийг К болон L хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	25		Улсын геологийн иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд 2016-2020 онд нэгтгэх төслийн 2018 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын А/03 дугаар тушаалаар батлан К хавтгайн нутаг дэвсгэрийн 25%-ийг хамруулахаар хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. 2018 оны хээрийн болон суурин боловсруулалтын судалгааны ажлын хэмжээ, арга аргачлал, төсвийг ЭБМЗ-ийн 2018 оны 3-р сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж УУХҮС-ын 6-р сарын 21-ний өдрийн А/154 дүгээр тушаалаар баталсан. Улсын геологийн иж бүрдэл зургийг К хавтгайн хэмжээнд нэгтгэх ажилд 2018 онд 408,530,683.0 төгрөг батлуулж, 5 дугаар сарын байдлаар 158,833,556.0 төгрөгийн гүйцэтгэлтэй байна.	70

			Монгол орны L хавтгайн хэмжээнд ажлыг эхлүүлэхээр төсвийг тооцон холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн хэдий ч 2018 оны төсөв хязгаартай батлагдсан тул тухайн төслийг дараа оноос эхлэхээр МУ-ын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл болон 2019 оны төсвийн хүрээний саналд тусгуулахаар холбогдох материалыг боловсруулан 2018.03.09-ний өдрийн 03/645 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.	
	Агаарын геофизикийн судалгааны ажилд хамрагдах газар нутгийн хэмжээ, хувиар	15	Монгол орны баруун өмнөд хэсэгт буюу Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь аймгуудын урд хэсгийн нийт 207,094.0 км2 талбайг хамруулан 2014-2017 онд гүйцэтгэсэн 1:200000-ны масштабын агаарын геофизикийн 5 сүвгийн судалгааны Алтай-1, Алтай-2 төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2018.04.12-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 13.2%-ийг хамруулсан. Нутаг дэвсгэрийн 6.6%-ийг хамарсан Ховд-1 төслийн гүйцэтгэгчээр шалгарсан "Алтайн хар азарга групп" ХХК-тай байгуулсан гэрээг судалгааны үндсэн ажил болох агаарын геофизикийн хэмжилтийг гүйцэтгээгүй үндэслэлээр 2018.06.15-ны өдрийн Захиалагч /УУХҮЯ-ны ТНБД/-ийн 03/1638 тоот шийдвэрээр цуцалсан. Энэ судалгааг 2019 онд шинээр хэрэгжүүлэхээр МУ-ын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл болон 2019 оны төсвийн хүрээний саналд тусгуулахаар холбогдох материалыг боловсруулан 2018.03.09-ний өдрийн 03/645 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.	70
	Геохимийн зураг зохиох ажилд хамрагдах газар нутгийн хэмжээ, хувиар /1:1000000-ын масштаб/	20	Геохимийн судалгааны ажлыг эхлүүлэхээр төсвийг тооцон холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн хэдий ч төлөвлөгөөт оны Үндсэн чиглэл болон төсөв хязгаартай батлагдсан тул тухайн төслийг 2019 оноос эхлэхээр МУ-ын нийгэм, эдийн засгийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл болон 2019 оны төсвийн хүрээний саналд тусгуулахаар холбогдох материалыг боловсруулан 2018.03.09-ний өдрийн 03/645 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.	0
	Томоохон хотуудын геоэкологи, гидрогеологийн судалгаа болон сэдэвчилсэн	6	1. Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологи-2017 төслийн ажилд 2018 онд 766,139,254.0 төгрөгийн төсөв баталж, 5 дугаар сарын байдлаар 251,661,700.0 төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Төслийн 2018 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын төсөл, төсөвт хийх тодотголыг ЭБМЗ-өөр 2018 оны 4-р сарын 12-ны өдөр хэлэлцэж, УУХҮС-ын 6-р сарын 21-ний өдрийн А/156 дугаар тушаалаар батлан судалгааны ажлыг эхлүүлсэн.	70

		судалгааны ажлын тоо		2. Бүс нутгийн хөгжлийг хангах, эрдэс түүхий эдийн нөөц, баялгийг өсгөх зорилгоор нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан голлох ашигт малтмалын судалгаа (АМС-2017)-ны ажлын 2018 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар батлан хээрийн судалгааны ажлыг эхлүүлээд байна. Төслийн 2017 оны хээрийн судалгаа болон 2018 оны суурин боловсруулалт, геофизикийн ажлын үр дүнгээр Увс, Ховд, Баянхонгор, Өмнөговь аймгийн нутагт хэд хэдэн хэтийн төлөвтэй талбайг ялган өрөмдлөгийн ажил гүйцэтгэхээр ажиллаж байна. 2018 онд 6,456,322,916.0 төгрөгийн төсөв баталж, 5 дугаар сарын байдлаар 1,179,961,249.0 төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 3. МУ, БНХАУ, БНСУ, ОХУ, БНКаЗУ-ын хамтарсан "Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" төслийн 3-р шатны ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2017 оны 11-р сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2018 оны 1-р сарын 31-ний өдрийн А/16 дугаар тушаалаар хүлээн авсан. МУ, БНХАУ, БНСУ, ОХУ, БНКаЗУ-ын хамтарсан "Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени" төслийн 4-р шатны ажлын гүйцэтгэчийг шалгаруулах тендер 4-р сарын 19-ний өдөр сонгон шалгаруулалт зарлаж, 5-р сарын 21-нд хүлээн авсан. Оролцогч хуулийн этгээдийн санхүүгийн саналыг 2018.06.21-ний өдөр нээсэн. Шалгарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулахаар ажиллаж байна. 2018 онд 90,000,000.0 төгрөгийн төсөв баталсан. 4. Геомэдээллийн сан-2013 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2018 оны А/16 дугаар тушаалаар хүлээн авсан. Энэхүү ажлын үр дүнд 1:1000000-ын масштабын геоморфологи, 1:500000-ны масштабын гидрогеологи, геологийн зураг, холбогдох мэдээллийн санг үүсгэн геологийн архивт тушаасан. 5. Сансрын зургийн тайлалт-2013 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 2018 оны А/16 дугаар тушаалаар хүлээн авсан. Энэхүү ажлаар сансрын ASTER төрлийн хиймэл дагуулын 14 сувгийн тоон мэдээллийг боловсруулан 600 сцен, 1:200000-ны масштабын 337 хавтгайн зургуудад буюу нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд АНУ-ын USGS-ын баталгаажсан томъёоллын аргачлалаар боловсруулалт тайлалт хийж үр дүнг Геологийн фондод оруулсан. 6. Металлогени-2014, Баруун Монголын цул сульфид төслүүийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр ажиллаж байна.
--	--	-------------------------	--	--

4.2.	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.69, ЭЗСХ-ийн 1.3.1 дэх заалт	"Алт-2" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол орны алтны хэтийн төлөвийг тогтоох	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	30	1.8 Улсын төсөв	Монгол орны төв, зүүн бүсийн алтны нөөцийн хэтийн төлвийн үнэлгээ хийх геологийн судалгааны ажлын "ТЗМ-Алт-2017" төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны А/03 дугаар тушаалаар батлуулсан. Төслийн 2018 онд гүйцэтгэх хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр 2018 оны 4-р сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮС-ын 6-р сарын 21-ний өдрийн А/157 дугаар тушаалаар батлуулсан. Хээрийн судалгааны ажлыг гүйцэтгэснээр төлөвлөгөөт онд нутаг дэвсгэрийн 30%-ийг хамруулна. 2018 онд 921,209,736.0 төгрөгийн төсөв баталж, 5 дугаар сарын байдлаар 345,624,635.0 төгрөгийн гүйцэтгэлтэй байна.	40
4.3.	МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.24, ЭЗСХ-ийн 2.2.1 дэх заалт	Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрү үдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	45	2600.0 Хувийн хөрөнгө оруулалт	Оюу толгойн зэс алтны ордыг ашиглах далд уурхайн бүтээн байгуулалтад 2018 онд 1,076.3 сая ам.доллар оруулахаар төлөвлөснөөс эхний улирлын байдлаар 477.4 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг оруулсан байна. 2018 онд далд уурхайн хэвтээ малталтын нэвтрэлтэд 11159 метр нэвтрэхээр төлөвлөснөөс 5 дугаар сарын байдлаар 4110 метр, мөн конвейрын налуу аманд 4320 метр нэвтрэлт хийхээр төлөвлөснөөс 1301.4 метр тус тус нэвтрэч, 5 дугаар босоо амны нэвтрэлт 92.5 метрээр гүнзгийрсэн байна. Далд уурхайн нэвтрэлт бүтээн байгуулалтын ажил хийхээс гадна ил уурхай, баяжуулах үйлдвэр ажиллаж байна. 2018 онд ил уурхайгаас 43328 мян.тонн хүдэр олборлохоор төлөвлөснөөс эхний 5 сарын байдлаар 16716 мян.тонн хүдэр олборлосон байна. Баяжуулах үйлдвэр 2018 онд 582.6 мян.тонн зэсийн баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөснөөс эхний 5 сарын байдлаар 21.9 хувийн дундаж агуулагатай 296.6 мян.тонн баяжсал үйлдвэрлэн 303.3 мян.тонн баяжмал экспортлосон байна. Оюутолгой ХХК нь 1 дүгээр улирлын байдлаар улсын төсөвт 94377.5 сая төгрөг, орон нутгийн төсөвт 26567.2 сая төгрөгийн тус тус оруулж орон нутгийн хөгжлийн санд 5 сая ам.доллар зарцуулахаас одоогийн байдлаар 2.7 сая ам.долларыг оруулаад байна.	70

		Тавантолгойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хэрэгжүүлэх ажлын явц, хувиар	20	380.0 Хувийн хөрөнгө оруулалт	Таван толгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглан үйл ажиллагааг эрчимжүүлэх, дагалдах дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх тухай" танилцуулга боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зөвлөлийн 2018.05.14-ний өдрийн хуралд танилцуулж тэмдэглэл гаргуулан хэрэгжүүлсэн. "Таван толгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглан үйл ажиллагааг эрчимжүүлэх, дагалдах дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх тухай" ЗГ-ын тогтоолын төслийг холбогдох материалын хамт боловсруулан 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдөр, 5 дугаар сарын 30-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд танилцуулж тэмдэглэл гаргуулсан. Мөн Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцүүлж Зөвлөмж гаргуулсан. Улмаар Таван толгойн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэхээр Улсын Их хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 1 дэх дэд заалтад Таван толгойн нүүрсний ордод төрийн өмчит компани ашиглалтын үйл ажиллагаа явуулах, "ЭТТ" охин компанийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг хуваахгүйгээр шилжүүлэх, түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, оператор аж ахуйн нэгжээр олборлолтын үйл ажиллагааг тодорхой хугацаанд гүйцэтгүүлэх гэсний дагуу Засгийн газрын 2010 оны 272 дугаар тогтоол, ТӨХ-ны 2010 оны 425 дугаар тогтоолын дагуу 2010 оны 12 дугаар сарын 23-ны өдөр төрийн өмчит "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компани хэлбэрээр байгуулан ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Эрдэнэс-Тавантолгой" ХК-д шилжүүлсэн байдаг бол хөрөнгө оруулалтын гэрээний тухайд Засгийн газраас удаа дараа холбогдох тогтоол, шийдвэрүүдийг баталж, үүрэг даалгавар өгсөн хэдий ч өнөөдрийг хүртэлх хугацаанд нэг ч хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцэл хийгдээгүй байна. Харин Зүүн, Баруун Цанхид үйл ажиллагаа эрхлэх гадаад, дотоодын оператор компаниудыг сонгон шалгаруулж, хамтран ажиллаж тус заалтын хэрэгжилт хангагдсан тул уг заалтыг бүхэлд нь хүчингүй болгохоор мөн "Эрдэнэс таван толгой" ХК-ийн хувьцааны 30 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр үе шаттайгаар арилжаалж шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах зохицуулалттайгаар УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьсан. 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Тавантолгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэх эсэхийг УИХ дэмжээд байна.	70
--	--	--	----	----------------------------------	--	----

			Гацууртын төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар	20	150 Хувийн хөрөнгө оруулалт	"Сентерра гоулд" ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт орших Гацууртын алтны үндсэн ордын тусгай зөвшөөрлийн асуудал шүүхийн маргаантай, эцэслэн шийдэгдээгүй байна. Иймд Гацууртын төслийн хэрэгжилтийн асуудалд хүндрэл учраад байна.	./-/
1.4.	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, 4, ЗГҮАХ-ийн 2.70-2.73, ЭЗСХ-ийн 1.3.8 дахь заалт	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн барилгын ажлыг эхлэх бэлтгэлийг хангах, хувиар	10	131 Гадаад эх үүсвэр	1."Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК-ийн төлөөлөгч нар 2018 оны 02 дугаар сарын 06-20-ны өдрүүдэд БНЭУ-д албан томилолтоор ажиллаж Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй EIL компанийн ажлын гүйцэтгэлтэй танилцаж, "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн дунд шатны тайланг Зөвлөхөөс 2018.02.29-ний өдөр хүлээн авсан. Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн дундын буюу явцын тайланг ирүүлсэнтэй холбогдуулан БНЭУ-ын Зөвлөх түүнд хөндлөнгийн хяналт тавьж буй Итали Улсын "КТ-Кинетикс" компаниуд Монгол Улсад 2018 оны 04 дүгээр сарын 22-26-ны өдрүүдэд албан айлчлал хийсэн. Айлчлалын үеэр НТЭЗҮ-ийн урьдчилсан төслийг Захиалагчид танилцуулсан бөгөөд талуудын оролцсон техникийн зөвлөлдөх уулзалтуудыг хийсэн. ЗГ-ын 2018.05.02-ны өдрийн хуралдаанаар БНЭУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн явц болон Энэтхэгийн Зөвлөх компани "Инженерс Индиа Лимитед" компанийн боловсруулж буй нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн дунд шатны тайлангийн талаар болон түүнд хөндлөнгийн хяналт тавин ажиллаж буй Итали Улсын "КТ-Кинетикс СПА" компанийн зүгээс тайлангийн талаар гаргасан санал, зөвлөмжүүдийг танилцуулж ЗГ-ын 2018.05.02-ны өдрийн 20 дугаар тэмдэглэл гарсан.Зөвлөхөөс ирүүлсэн НТЭЗҮ-ийн дунд шатны тайланд төслийн хөрөнгө оруулалтын зардал харьцангуй өндөр гарсантай холбогдуулан Захиалагчийн зүгээс үйлдвэрийн болон түүхий тос дамжуулах хоолойн техник, технологийн сонголт эдийн засгийн тооцооллыг олон улсын жишиг үнээр дахин тооцоолж тайланд туусгаж ирүүлэх шаардлагыг тавьсан бөгөөд Энэтхэгийн тал саналыг хүлээн авч дахин тооцооллыг хийн 2018.05.21-ний өдөр Захиалагчид ирүүлээд байна. Төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийн эцсийн тайланг 2018.06.20-ны өдөр БНЭУ-ын Зөвлөхөөс ирүүлэх бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хүлээж авахаар ажиллаж байна. 2.ЗГ-ын 2018 оны 2 дугаар тогтоолоор ГТБҮ-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг МУ-ын Хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр шийдвэрлэж УУХҮЯам, ТӨБЗГ, Хөгжлийн банк болон Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК, 4 байгууллага нь Зээлийн болон Барьцааны гэрээг 2018.04.13-ны өдөр байгуулсан. 3.ЗГ-ын 2018 оны 28 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэр барих зорилгоор Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт орших 150 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан. Үйлдвэрийн гаднах дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд "Сайншанд-Газрын тос	70

				боловсруулах үйлдвэр" хүртэлх салаа төмөр замын ажлын Ерөнхий гэрээг 2018.03.30-ны өдөр "УБ Төмөр зам" ХНН болон "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК нарын хооронд байгуулсан" Дээрх салаа төмөр замын техник, эдийн үндэслэл болон нарийвчилсан зураг төслийг УБ төмөр замын Техникийн бодлого, зураг төсөл, инженерийн алба гүйцэтгэж дуусган ажил гүйцэтгэх гэрээ 2018.06.06-ны өдөр "МГТБҮ" ТӨХХК-тай байгуулсан. "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" хүртэлх хатуу хучилттай автозамын ажлын Ерөнхий гэрээг 2018.01.31-ний өдөр Батлан хамгаалах яам МГТБҮ ТӨХХК нар байгуулсан бөгөөд автозамын техник, эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан зураг төслийн ажлыг "Эм Си Пи Си Жи Ар" ХХК-иар гүйцэтгүүлж байгаа бөгөөд ажил гүйцэтгэх гэрээг Батлан хамгаалах яам болон "МГТБҮ" ТӨХХК нар 2018.06.12-ны өдөр байгуулаад байна. "Сайншанд-Газрын тос боловсруулах үйлдвэр" хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын Ерөнхий гэрээг 2018.03.06-ны өдөр "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК болон "МГТБҮ" ТӨХХК нар байгуулсан. ЦДАШ-ын техник, эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан зураг төслийн ажлуудыг гүйцэтгэж байна. - Үйлдвэрийн талбайн тэгшилгээ, үйлдвэрийг хашаажуулах болон ойн зурвас хийж гүйцэтгэх ажлын ерөнхий гэрээг БХБЯ болон "МГТБҮ" ТӨХХК нар 2018.05.02-ны өдөр байгуулан ажиллаж байна	
	Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар	100	2.5 Хувийн хөрөнгө оруулалт	1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нэгжээс "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл"-ийг 2018 оны 03-06 дугаар сарын хооронд боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр ажиллаж байна. 2. "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл"-ийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэн тайланг 2018.05.20-нд хүлээн авсан бөгөөд үнэлгээний тайланг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагаар батлуулах хүсэлтийг хүргүүлээд байна. 3. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийн төслийг Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төслийн нэгжтэй хамтран боловсруулж, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газраас ирүүлсэн саналыг тусган УУХҮ-ийн сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна.	40

		"Уул уурхай, металлургийн цогцолбор" төслийн 2 дугаар шатны бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	20	200	ТХХТ	1.Дэлхийн банкны "Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл"-ийн хүрээнд "Дархан-Сэлэнгийн бүс нутагт хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл"-ийн техник-эдийн засгийн үндэслэлийг Канад Улсын "Hatch" компани хийж гүйцэтгэн 2017 оны 9 дүгээр сард УУХҮЯ-ний ХҮБГ болон ажлын хэсэгт танилцуулан холбогдох засваруудыг оруулж хүлээлгэн өгсөн. Мөн "Байгал орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ"-ний урьдчилсан судалгааны тайланг Монгол Улсын "Экотон", болон "Ажид", "Экосфер" ХХК-иудын түншлэлийн баг боловсруулсан ба Төмөртэйн ордын уурхайн нөлөөллийн бүсэд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор иргэдэд газар олгосон асуудлыг шийдвэрлүүлэх, эсвэл нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах шаардлага үүсч байгаатай холбогдуулан Дэлхийн банкны УУДБХОДТөслийн хүсэлтээр гэрээг 2018 оны 4 дүгээр улирал хүртэл хугацаагаар сунган ажиллаж байна. 2.Төмөртэйн уурхайд байгуулах хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн барилгын ажлыг 2018 оны 8 дугаар сард эхлүүлж 2020 оны 9 дүгээр сард дуусган мөн оны 12 сард үйлдвэрийг бүрэн ашиглалтанд хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажлууд хийгдэж байна.	40
		Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	10	607.5	Хувийн хөрөнгө оруулалт	1.УУХҮЯ, БОАЖЯ, ННБХҮҮ төслийн нэгж, "Грийн Трендс"ХХК-ний төлөөллүүд 2018.05.07-ны өдөр "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн төслийн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний ажлын явцын талаар санал солилцож, эцсийн тайланг 2018 оны 8 дугаар сард Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй компаниас хүлээн авахаар ажиллаж байна. 2. БНХАУ-ын Үндэсний газрын тосны корпорац (CNPC)-ийн охин компани болох "Хуан Чү барилга угсралт, инженеринг" компани (HQC) болон "Хятадын газрын тосны шугам хоолой" компани (CPR)-ууд уг төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхлоо илэрхийлсэн.Төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллахаар хүсэлт ирүүлсэн БНХАУ-ын аж ахуйн нэгжүүдтэй "Хамтран ажиллах санамж бичиг" байгуулахаар ажиллаж байна. 3. "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн байршлыг тогтоож Төв аймгийн Баяндэлгэр сумын 2017.12.18-ны өдрийн ИТХ-н хуралдаанаар танилцуулан 2018 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан бөгөөд Төв аймгийн 2018.01.12-ны өдрийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж аймгийн тусгай хэрэгцээнд авсан. Хийг дамжуулах шугам хоолойн трассын байршлыг нарийвчлан тогтоож, хий дамжуулах хоолой дайран өнгөрөх газрыг аймгийн тусгай хэрэгцээнд Төв аймгийн ИТХ-ын 2018.01.12-ны өдрийн 08 дугаар тогтоолоор аймгийн тусгай хэрэгцээнд авсан.	40

						4. "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн төслийн 2018 оны үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор "Улаанбаатар хотын байгалийн хийн түгээх шугам сүлжээний трасс, технологийн судалгаа" хийх зөвлөх үйлчилгээг үзүүлэх нээлттэй тендер зарлагдсан бөгөөд 2018.06.22-ны өдөр тендерийг нээхээр ажиллаж байна. Мөн хот доторх түгээх сүлжээг Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах ажлын хүрээнд 2-р бүс /гэр хорооллын/ БЗД, СХД, ЧД, ХУД, БГД-ын засаг даргын тамгын газартай хамтран гэр хорооллын айл өрх, хүн ам, гэр байшингийн нарийвчилсан тоог хүлээн авч тус судалгаа, мэдээллийн дагуу анхан шатны боловсруулалтыг хийж байна.
						5. "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр"-ийн төслийн үйлдвэрлэл болон дамжуулахтай холбоотой олон улсын ISO, ГОСТ стандартуудыг орчуулан техникийн нөхцөлүүдийг MNS стандарт руу хөрвүүлэхэд бэлэн болгоод байна.
4.5.	МУТХҮБ-2030-ын 2.1.3, зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.71 дэх заалт	Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих	Бэлтгэл ажлын явц, хувиар	100	-	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг тус яамнаас боловсруулан 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 03/850 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн ба тус саналд "Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих " зорилт арга хэмжээг тусгаагүй болно. Мөн тус яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газраас "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2017.03.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, 88 дугаар тогтоол батлуулсан. Тогтоолын нэгдүгээр заалтаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийг Өмнөговь аймгийн Ханбогд суманд байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд УУХҮЯ-ны дэргэд "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр"-ийн төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулагдан ажиллаж байна. Хариуцан ажиллаж буй тус яамнаас тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Иймд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1 дүгээр зүйлийн 4.5-д тусгагдсан "Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих" төслийг хасуулах саналтай байна.
Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ, хувиар						50.00

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2018-06-22

"МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ"- Д ТУСАГДСАН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2018 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

Д/д	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2018 онд хүрэх түвшин, үр дүн	2018 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /тэрбум төгрөг/	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ					Хариуцах нэгж	ГБГ		УУБГ		ХҮБГ	
							ЗА	ШҮ	Д	Т	Н		ЗА	Ш	ЗА	Ш	ЗА	Ш
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО																		
Зорилт 4. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.																		
4.1	МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.59-2.61, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /цаашид ТЭБСББ/-ын 3.2.2 дахь заалт	Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар /1:50000 масштаб/ Улсын геологийн их бүрдэл зургийг К болон L хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар Агаарын геофизикийн судалгааны ажилд хамрагдах газар нутгийн хэмжээ, хувиар Геохимийн зураг зохиох ажилд хамрагдах газар нутгийн хэмжээ, хувиар /1:1000000-ын масштаб/ Томоохон хотуудын геоэкологи, гидрогеологийн судалгаа болон сэдэвчилсэн судалгааны ажлын тоо	42 25 15 20 6	11.8 Улсын төсөв	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /цаашид "УУХҮЯ" гэх/	1	1	1			1	ГБГ	1	1			
								1				0	ГБГ		1			
								1				0	ГБГ		1			
								1				0	ГБГ		1			
								1				0	ГБГ		1			
4.2	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.69, ЭЗСХ-ийн 1.3.1 дэх заалт	"Алт-2" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол орны алтны хэтийн төлөвийг тогтоох	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	30	1.8 Улсын төсөв	УУХҮЯ	1	1	1			1	ГБГ	1	1			

4.3	МУТХҮБ-2030-ын 2.1.4, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.24, ЭЗСХ-ийн 2.2.1 дэх заалт	Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	45	2600 Хувийн хөрөнгө оруулалт	УУХҮЯ	1	1	1	1	УУБГ				1	1			
			Тавантолгойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хэрэгжүүлэх ажлын явц, хувиар	20	380 Хувийн хөрөнгө оруулалт				1		0	УУБГ					1		
			Гацууртын төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар	20	150 Хувийн хөрөнгө оруулалт				1		0	УУБГ					1		
4.4	МУТХҮБ-2030-ын 2.1.3, Зорилт 3, 4, ЗГҮАХ-ийн 2.70-2.73, ЭЗСХ-ийн 1.3.8 дахь заалт	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн барилгын ажлыг эхлэх бэлтгэлийг хангах, хувиар	10	131 Гадаад эх үүсвэр	УУХҮЯ, ҮХГ	1	1		1	ХҮБГ						1	1	
			Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар	100	2.5 Хувийн хөрөнгө оруулалт				1		0	ХҮБГ							1
			"Уул уурхай, металлургийн цогцолбор" төслийн 2 дугаар шатны бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	20	200 ТХХТ				1			0	ХҮБГ						1
			Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	10	607.5 Хувийн хөрөнгө оруулалт				1			0	ХҮБГ						1
4.5	МУТХҮБ-2030-ын 2.1.3, зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.71 дэх заалт	Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих	Бэлтгэл ажлын явц, хувиар	100	-	УУХҮЯ, ҮХГ	1	1		1	ХҮБГ						1	1	
Нийт дүн							5	14	3	2	5			2	6	1	3	2	

Тайлбар: ЗАХ-зорилт, арга хэмжээний тоо, ШҮ-шалгуур үзүүлэлтийн тоо, Хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ-тус яамны хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн тоо, Д-дангаар хэрэгжүүлэх, Т-толгойлон хэрэгжүүлэх, Н-нийт хэрэгжүүлэх зорилтын тоо, ГБГ-Геологийн бодлогын газар, УУБГ-Уул уурхайн бодлогын газар, ХҮБГ-Хүнд үйлдвэрийн бодлогын газар

Танилцсан: ХШҮДАГ-ын дарга

Ц.Одхүү

Дүн шинжилгээ хийсэн: ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн

Н.Баатар /2018.06.14/

Н.Баатар 18.06.14



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТӨМДӨГЛӨЛ

2018 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 05

Холбоотой хууль

Удирдлагын зөвлөлийн хурал Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан өрөөнд 15:00 цагт эхлэв. Хурлыг Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал удирдав.

Хуралдаанд оролцсон:

Г.Нандинжаргал	Төрийн нарийн бичгийн дарга, удирдлагын зөвлөлийн дарга
Ч.Чулуунбат	Түлшний бодлогын газрын дарга, зөвлөлийн гишүүн
Ц.Одхүү	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, зөвлөлийн гишүүн
Т.Зууннаст	Уул уурхайн бодлогын газрын даргын оронд тус газрын ахлах мэргэжилтэн
О.Энхбаяр	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын оронд тус газрын ахлах мэргэжилтэн
Б.Анхбаяр	Хүнд үйлдвэрийн бодлогын газрын даргын оронд тус газрын Метал бус үйлдвэрлэлийн хэлтсийн дарга
Б.Баяржаргал	ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн
Н.Итгэл	Төрийн нарийн бичгийн даргын туслах, удирдлагын зөвлөлийн нарийн бичгийн дарга

Хуралдаанд ирвэл зохих 9 гишүүнээс ирсэн 6, гишүүдийн 66,6%-ийн ирцтэйгээр хуралдав.

Хэлэлцсэн нь:

Холбогдох журмын даргуу яамны 2018 оны хагас жилийн тайланг Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхтэй холбогдуулан Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Б.Баяржаргал хийв.

Б.Баяржаргал: Хагас жилээр Үндсэн чиглэлийн 14 арга хэмжээний биелэлт 50,0%, үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт 61,7%, хууль тогтоомжийн биелэлт 82,3%-тай тус тус үнэлэгдсэн. Үндсэн чиглэлд тусгагдсан 2 арга хэмжээний биелэлтэд "0" үнэлгээг тус тус өгсөн.

Г.Нандинжаргал: 0 үнэлгээтэй ямар ажлууд байна бэ?

Ц.Одхүү: Нэг нь геохимийн зураг зохиох ажил хийгдэж эхлээгүй, нөгөө нь Эрдэнэт хотод ээсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих ажил нь манай яамнаас өгсөн саналд тусгагдаагүй. Энэ ажил дээр Хүнд үйлдвэрийн бодлогын газраас анхаарах хэрэгтэй байна.

Б.Анхбаяр: Манай газраас энэ ажлын талаар зохих тайлбарыг бэлтгэн хүргүүлж байгаа.

Г.Нандинжаргал: За хагас жилийн тайлан, дүнг сонслоо. Хурлын шийдвэрийн төслөө танилцуулчих.

Б.Баяржаргал: Хагас жилийн тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагад нь хүргүүлэх, биелэлттэй холбогдуулан Үндсэн чиглэлийн биелэлтэд "0" хувьтай үнэлэгдсэн 2 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Геологийн бодлогын газрын дарга /Б.Мөнхтөр/, Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга /Д.Даваадорж/ нарт; засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Б.Элбэгзаяа/-т; Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн удаашралтай /40-өөс 70 хувьтай/ арга хэмжээг эрчимжүүлэх, жилийн эцсээр гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллахыг холбогдох нэгжийн дарга нарт үүрэг болгох гэж санал оруулж байна.

Г.Нандинжаргал: Гишүүд санал нэг байна уу?

Ч.Чулуунбат: санал нэг байна.

Т.Зууннаст: санал нэг байна.

О.Энхбаяр: санал нэг байна.

Б.Анхбаяр: санал нэг байна.

Ц.Одхүү: Үнэлгээний дүгнэлт зөвлөмжийг бүх газруудад хүргүүлнэ, тэндээс та бүхэн анхаарах асуудалтай ажлуудынхаа танилцаад жилийн эцсийн тайлан биелэлт гаргахдаа анхаарч ажиллах шаардлагатай байна.

Г.Нандинжаргал: Тайлан хүргүүлэх тоотын төсөлтэй гишүүд танилцаад гарын үсэг зураад тайлангуудыг холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлъя.

Шийдвэрлэсэн нь:

Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг холбогдох журмын даргуу Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлэхээр шийдвэрлэв.

Удирдлагын зөвлөлийн хурал 15:30 цагт дуусав.

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:


УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.НАНДИНЖАРГАЛ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Н.ИТГЭЛ



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2018 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Удирдлагын зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн 2018 оны хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга.
2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны хагас жилийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга.
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2018 оны хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Б.Баяржаргал хийв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлтэд "0" хувьтай үнэлэгдсэн 2 арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Геологийн бодлогын газрын дарга /Б.Мөнхтөр/, Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга /Д.Даваадорж/ нарт, бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Б.Элбэгзаяа/-д тус тус үүрэг болгов.
2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн удаашралтай /40-өөс 70 хувьтай/ арга хэмжээг эрчимжүүлэх, жилийн эцсээр гүйцэтгэлийг бүрэн хангаж ажиллахыг холбогдох нэгжийн дарга нарт мөн үүрэг болгов.
3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хагас жилийн байдлаар хийсэн явцын үнэлгээний дүн, тайланг холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд нь Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТӨРИЙН НАРИЙН БҮЛГЭЙН
ДАРГА



Г.НАНДИНЖАРГАЛ

УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР, ТЭДГЭЭРИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭЛ

2018 оны 06 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар			Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгө, төсвийн дүн /төгрөг/				
ЗАХ	ШҮ	ҮЧ			Сангийн яаманд хүргүүлсэн		УИХ-аар баталсан	УУХҮЯ-ны төлөвлөлт	УУХҮЯ-ны гүйцэтгэл
					УУХҮС, 2017.03.02, 01/477	УУХҮС, 2017.04.14, 03/850			
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО									
Зорилт 4. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.									
1	1	4.1	Геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар /1:50000 масштаб/	6 000 000 000	12 800 000 000	11 800 000 000	4 693 697 411	1 061 156 045
				Улсын геологийн иж бүрдэл зургийг К болон L хавтгайн хэмжээнд нэгтгэх ажлыг хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	600 000 000			408 530 683	158 833 556
				Агаарын геофизикийн судалгааны ажилд хамрагдах газар нутгийн хэмжээ, хувиар	1 300 000 000				
				Геохимийн зураг зохиох ажилд хамрагдах газар нутгийн хэмжээ, хувиар /1:1000000-ын масштаб/	500 000 000				
				Томоохон хотуудын геоэкологи, гидрогеологийн судалгаа болон сэдэвчилсэн судалгааны ажлын тоо	1 400 000 000			766 139 254	
	2 000 000 000	6 456 322 916	1 179 961 249						
		90 000 000							
			Бусад-2 ЛУГА байгуулах, салбарын эрх зүйн орчин	1 100 000 000					
2	6	4.2	"Алт-2" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол орны алтны хэтийн төлөвийг тогтоох	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	1 800 000 000	1 800 000 000	1 800 000 000	921 709 736	345 624 635
Геологийн салбарын зарцуулах хөрөнгийн дүн					14 700 000 000	14 600 000 000	13 600 000 000	13 336 400 000	2 745 575 485
3	7	4.3	Уул уурхайн салбарын томоохон	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	2 600 000 000 000	2 600 000 000 000	2 600 000 000 000		-

	8	төсөл хөтөлбөрүүдийн н үйл	Тавантолгойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээний дагуу хэрэгжүүлэх ажлын явц, хувиар	680 000 000 000	380 000 000 000	380 000 000 000	-	-	
	9	ажиллагааг эрчимжүүлэх	Гацууртын төслийг хэрэгжүүлэх ажлын явц, хувиар	288 809 000 000	150 000 000 000	150 000 000 000	-	-	
Уул уурхайн салбарын зарцуулах хөрөнгийн дүн				3 568 809 000 000	3 130 000 000 000	3 130 000 000 000	-	-	
4	10	4.4	Хүнд аж үйлдвэрийн бүтээн	Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн барилгын ажлыг эхлэх бэлтгэлийг хангах, хувиар	534 600 000 000	131 000 000 000	131 000 000 000	-	-
	11	байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар	78 400 000 000	2 500 000 000	2 500 000 000	-	-	
	12		"Уул уурхай, металлургийн цогцолбор" төслийн 2 дугаар шатны бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	200 000 000 000	200 000 000 000	200 000 000 000	-	-	
	13		Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	1 215 000 000 000	607 500 000 000	607 500 000 000	-	-	
5	14	4.5	Эрдэнэт хотод зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр барих	Бэлтгэл ажлын явц, хувиар	-	-	-	-	-
Хүнд үйлдвэрийн салбарын зарцуулах хөрөнгийн дүн				2 028 000 000 000	941 000 000 000	941 000 000 000	-	-	
1			Улсын төсвийн хөрөнгийн дүн	14 700 000 000	14 600 000 000	13 600 000 000	13 336 400 000	2 745 575 485	
2			Хувийн хөрөнгө оруулалтын дүн	4 862 209 000 000	3 740 000 000 000	3 740 000 000 000	-	-	
3			Гадаад эх үүсвэрийн дүн	534 600 000 000	131 000 000 000	131 000 000 000	-	-	
4			ТХХТ-ийн дүн	200 000 000 000	200 000 000 000	200 000 000 000	-	-	
Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд зарцуулах нийт хөрөнгийн дүн				5 611 509 000 000	4 085 600 000 000	4 084 600 000 000	13 336 400 000	2 745 575 485	

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

Нэгтгэлийг хянасан: ХШУДАГ-ын дарга

Түүвэрлэн нэгтгэсэн: ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн

Ц.Одхүү

Н.Баатар //2018.06.24/

Н.Баатар
18.06.24